



МОНГОЛ УЛС
ХӨВСГӨЛ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 08 сарын 01 өдөр

Дугаар А/405

Мөрөн сум

Үйл ажиллагааны жагсаалт
төсөвт өртөг батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 60 дугаар зүйлийн 60.1.5, 66 дугаар зүйлийн 66.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, 41 дүгээр зүйлийн 41.2.3, 41.2.6, 65 дугаар зүйлийн 65.1.1, 65.1.4, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1 дэх заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:


1.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар “Эрүүл чийрэг-Эр хүн” арга хэмжээг хэрэгжүүлэхэд шаардлагатай урвалж оношлуур худалдан авах ажлын жагсаалт, төсөвт өртгийг хавсралтаар баталсугай.

2.Батлагдсан арга хэмжээний худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу зохион байгуулж ажиллахыг аймгийн Худалдан авах ажиллагааны газрын дарга (Б.Должинсоргодог)-д үүрэг болгосугай.

3.Худалдан авах ажлыг үр дүнтэй зохион байгуулж ажиллахыг Нийгмийн бодлогын хэлтсийн Эрүүл мэндийн бодлого үйл ажиллагаа зохион байгуулах мэргэжилтэн (О.Дагиймаа)-д үүрэг болгосугай.

4.Энэхүү захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч (Б.Батбилгүүн)-д даалгасугай.

ДАРГА



П.ЛХАГВАЖАВ

Аймгийн Засаг даргын 2024 оны 08 дугаар
сарын 01-ний өдрийн А/10 дугаар
захирамжийн хавсралт

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨӨР 2024 ОНД
“ЭРҮҮЛ ЧИЙРЭГ ЭХ ХҮН” АРГА ХЭМЖЭЭНИЙ ХҮРЭЭНД
НИЙЛҮҮЛЭХ АЖЛЫН ЖАГСААЛТ, ТӨСӨВТ ӨРТӨГ

№	Үйл ажиллагаа	Шаардагдах хөрөнгө /сая. Төг/
1	Эрэгтэйчүүдийн эрүүл мэндийн үзлэг хийхэд шаардлагатай эм эмнэлгийн хэрэгслийн зардалд	10,000,000
2	Зорилтот бүлгийн хүн амын эрүүл мэндийн үзлэг, эрсдэлт бүлгийн олон нийтийг илрүүлэх тандах үйл ажиллагаанд	10,000,000
	Нийт дүн	20,000,000

_____оОо_____